

НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 7 САРЫН ТАЙЛАН

Нийтийн номын сан нь 7 сард хүүхдүүддээ зориулан “Зуны Зугаатай Өдрүүд” аян нээлтээ хийж хүүхдүүд бие биентэйгээ танилцан, “Найзуудаасаа суралцацгаая” хөтөлбөрийн хүрээнд харилцан бие биендээ шатар, даам, шоо эвлүүлэхийг зааж өгч цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэн мөн 3D зураг харж сурахаар идэвхтэй суралцацгаасан.



- “Найзуудаасаа суралцацгаая” хөтөлбөрийн хүрээнд харилцан бие биендээ шоо эвлүүлэхийг зааж өгч цагийг үр бүтээлтэй өнгөрүүлж байна.



- “Зуны Зугаатай Өдрүүд” аяны 3 дахь өдөр амжилттай явагдаж байна. Танин мэдэхүйн "АХА" тэмцээн зохион байгуулахад хүүхдүүд маш идэвхтэй оролцсон.



- “Зуны Зугаатай Өдрүүд” аян амжилттай үргэлжлэн явагдаж байна. Хүүхэд бүр зуны амралтын даалгавраа биелүүлэн өөрсдийн гараар тасалгааны цэцэг тарьж сурлаа.



- “Найзуудаасаа суралцацгаая” хөтөлбөрийн хүрээнд харилцан бие биендээ шатар даам тоглохыг заан суралцацгааж байна.



- “Зуны Зугаатай Өдрүүд” Шинэ номын болон Танин мэдэхүйн мэдээлэл бэлтгэн хүүхдүүддээ мэдээлэл өглөө.



- "Шинэ ном 2023" Хүүхдийн уншлагын танхимд шинээр ирсэн номоор үзэсгэлэн гаргасан.



- “Хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих жил”, “Зуны зугаатай амралт” хөтөлбөрийн хүрээнд “MAGIC BRUSH art room”-ийн О.Номин багштай хамтран зохион байгуулж байгаа сургалт амжилттай явагдаж 22 хүүхдэд хамрагдлаа.





- Байгууллагын цахим хуудасаар тогтмол танин мэдэхүйн мэдээ, мэдээлэлийг тасралтгүй оруулж нийт 30 мэдээлэл оруулсан байна.

- Номын фондны урагдаж гэмтсэн ном сэлбэн засалт хийж үйлчилгээнд гаргаж байна. Мөн хуучин сонингуудыг бор хавтслан үдэж янзлан архивласан. Үүнд ном 13, сонин 10

Статистак мэдээ:

Байнгын уншигч-277, ирэгсэд-3888, ном олголт 3707